

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

№ТУЗТ 02/2022

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Нийтэд санал болгох энгийн хувьцааны
тоо хэмжээ, нэгж энгийн хувьцааны үнийг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дэх хэсэг, 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.6, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2-т заасан “Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6.00 (зургаа) хувьтай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай.” гэснийг “Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 14,665,944 (арван дөрвөн сая зургаан зуун жаран таван мянга есөн зуун дөчин дөрөв) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай.” гэж өөрчилсүгэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 01/2021 тоот тогтоолын 3-т заасан “Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 5,536,868 (таван сая таван зуун гучин зургаан мянга найман зуун жаран найм) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргахаар тогтоосугай.” гэснийг “Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 14,665,944 (арван дөрвөн сая зургаан зуун жаран таван мянга есөн зуун дөчин дөрөв) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 3,855,654 (гурван сая найман зуун тавин таван мянга зургаан зуун тавин дөрөв) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргасугай.” гэж өөрчилсүгэй.
3. Энэ тогтоолын 1 болон 2-т заасан нийтэд санал болгох нэмж гаргаж буй энгийн хувьцааны тоо хэмжээ нийтдээ 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх ширхэг байхаар тогтоосугай.
4. Компанийн эргэлтэд гаргаж буй нийт 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх ширхэг нийтэд санал болгож буй энгийн хувьцааны нэг ширхэг бүрийн үнийг 115 (нэг зуун арван тав) төгрөгөөр тогтоож, нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/